



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 7/18

Өлгий

Авлигын эсрэг үйл ажиллагааны
2023 оны төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллахыг холбогдох байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг бүх сум, байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Б.Мухамед/-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Х.АРМАН

0101230124

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 сарын 20 өдрийн 1/12 тоот
захирамжийн хавсралт

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023.01.20

Өлгий хот

Зорилт	№	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хариуцах байгууллага
1. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	1.1	АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх	Жилийн турш	Сумдын Засаг даргын Тамгын газар, байгууллага, агентлагууд
	1.2	Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах		
	1.3	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;		
	1.4	Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх	Жилийн турш	ТЗУХэлтэс

2. АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, СУРГАЛТАД ХАМРУУЛАХ	2.1	Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах	Тухай бүр	ТЗУХэлтэс ХЭЗХэлтэс
	2.2	Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	Тухай бүр	ТЗУХэлтэс ХЭЗХэлтэс
	3.1	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	Тухай бүр	Аймаг, сумдын ЗДТГазар, Байгууллага, агентлагууд
3.АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТИЙН ХЯНАЛТЫГ БИЙ БОЛГОХ	3.2	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх		
	4.1	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх г.м/	Жилийн турш	Аймаг, сумдын ЗДТГ Байгууллага, агентлагууд
	4.2	Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;		
	4.3	Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны		
4. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ				

		дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.			
5. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ	5.1	Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	Тухай бүр	Аймаг, сумдын ИТХ, ЗДТГазар, Байгууллага, агентлагууд	
	5.2	Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгах			
	5.3	Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.			
6. ТӨРИЙН АЛБАНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТ, ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАСАН БАЙДЛЫГ ҮНДЭСЛЭН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ.	6.1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, тогтоол болон нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	Тухай бүр	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Төрийн албаны салбар зөвлөл	
	6.2	Төрийн захиргааны байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.			
7. ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРМЫГ ХЯЛБАРЧИЛЖ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРИМ ТӨРЛИЙН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛЭХ.	7.1	Тухайн байгууллагаас олгож байгаа зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, зөвшөөрөл эрхлэх дүгнэлт эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн журам болон жагсаалтын гаргаж цахим хуудсандаа байршуулсан байх.	Тухай бүр	Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, ОБГазар, МХГазар, Сумдын Засаг дарга	
	7.2	Тухайн зөвшөөрөл, гэрчилгээ эзэмшигчийн нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах.			

8. УЛСЫН ТӨСӨВ БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ХАРИУЦЛАГТАЙ БАЙХ ЗАРЧМЫГ МӨРДҮҮЛЭХ.	8.1	Хувь хүн, хуулийн этгээдээс төсвийн байгууллагад өгсөн хандив, тусламж гэх мэт төсвийн бус орлого, түүнийг олон нийтэд мэдээлэх.	Тухай бүр	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, сумдын ЗДТГазар,
	8.2	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод болгох Тухайн жилийн төсөв /1-р сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсанд байршуулах.	Төсвийн тухай хуульд заасан хугацаанд	
	8.3	Жилийн эцсийн санхүүгийн тайлан болон санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах		
	8.4	Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийн цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлэх.	Тухай бүр	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумдын Засаг даргын Тамгын газар, байгууллага, агентлагууд
	8.5	Концессын зүйлийн жагсаалт баталсан ИТХ-ын шийдвэрийг цахим хуудсанд байршуулах /нэмэлт өөрчлөлт орсон бол батлагдсанаас хойш ажлын 14 хоногийн дотор цахим хуудсанд байршуулах.	Төсвийн тухай хуульд заасан хугацаанд	
	8.6	Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.		
9. ТӨСВИЙН ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭХЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ.	9.1	Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлэгийн талаар Засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.mn цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэх.	Тухай бүр	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн

10. ТЕНДЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОЖ, ЦАХИМ ХЭЛБЭРТ БҮРЭН ШИЛЖҮҮЛЭХ.	9.2	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлыг төлөвлөх, батлахад иргэдийн оролцоог хангах талаар хийсэн хэлэлцүүлгийн баримтыг архивын нэгж болгон хадгалах	Тухай бүр	бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Сумдын Засаг даргын Тамгын газар, байгууллага, агентлагууд,
	10.1	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийг бүртгэлд хамруулан тухайн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг захиалагч байгууллагаас холбогдох байгууллагад хүргэх тогтолцоог бүрдүүлэх.	Жилд	Орон нутгийн өмчийн газар
	10.2	Худалдан авах үйл ажиллагааны бүх тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтын зарыг www.bayan-olgi.gov.mn , байгууллагын албан ёсны цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр зарлан нийтэд мэдээлэх, байршуулах.	Жилд	Орон нутгийн өмчийн газар
	10.3	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх, батлагдсан баримт бичгийг цахим хуудас www.bayan-olgi.gov.mn , байгууллагын цахим хуудаст тогтмол байршуулах, иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах.	Тухай бүр	Аймгийн ИТХ-ын ажлын алба, Хууль эрх, зүйн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар